



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Манхан хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Гэрээт аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 99019943 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.22. № 2/51  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БУЯНТ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.БАДАМХОРЛОО ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын санхүүгийн тайланд тусгасан 7040 м2 хэмжээтэй газар кадастрын зургаар 9000 м2 хэмжээтэй, 1960 м2-аар зөрүүтэй байгааг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлж хөрөнгөд бүртгээгүй, хүүхдийн хоол хүнс нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулах 2024.01.26-ны 04 тоот албан бичиг сумын ЗДТГ-т хүргүүлсэн ч зохион байгуулагдаагүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 8 зорилт 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан ч сумын Засаг даргаар баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код  | Балансын үзүүлэлт                                                     | Эхний үлдэгдэл               | Эцсийн үлдэгдэл              |
|-------------|-----------------------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                        | <b><u>79,688,243.22</u></b>  | <b><u>149,616,449.11</u></b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                                                 | 46,342,931.41                | 110,465,497.30               |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                                     | 46,342,931.41                | 110,465,497.30               |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                                                         | 46,342,931.41                | 110,465,497.30               |
| 31211       | Төрийн сангийн харилцах                                               | 46,342,931.41                | 110,465,497.30               |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                                                         | 199.81                       | 199.81                       |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                                                   | 199.81                       | 199.81                       |
| 3351        | Байгууллагаас авах авлага                                             | 199.81                       | 199.81                       |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                                 | 33,345,112.00                | 39,150,752.00                |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>                                             | -                            | 1,220,000.00                 |
| 35130       | Эм боох материал                                                      | -                            | 1,220,000.00                 |
| 35300       | Бэлэн бүтээгдэхүүн                                                    | -                            | 182,000.00                   |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>                                            | 33,345,112.00                | 37,748,752.00                |
| 35420       | Аж ахуйн материал                                                     | 16,308,740.00                | 27,907,790.00                |
| 35440       | Түлш, шатах тослох материал                                           | 1,140,000.00                 | 30,000.00                    |
| 35460       | Хүнсний материал                                                      | 11,202,995.00                | 5,117,585.00                 |
| 35470       | Бусад хангамжийн материал                                             | 4,693,377.00                 | 4,693,377.00                 |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>655,911,231.65</u></b> | <b><u>696,973,957.08</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                                                 | 655,911,231.65               | 696,973,957.08               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                                                   | 640,470,631.65               | 681,533,357.08               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц                                        | 687,940,912.38               | 727,285,912.38               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (121,515,972.03)             | (143,790,318.99)             |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 57,607,858.00                | 78,147,073.00                |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (28,164,775.67)              | (38,411,745.01)              |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | 58,441,681.00                | 77,985,081.00                |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (15,839,072.03)              | (21,682,645.30)              |
| 39217       | Ном                                                                   | 2,000,000.00                 | 2,000,000.00                 |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                                               | 15,440,600.00                | 15,440,600.00                |
| 39301       | Програм хангамж                                                       | 649,500.00                   | 649,500.00                   |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (649,500.00)                 | (649,500.00)                 |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө                                                | 15,440,600.00                | 15,440,600.00                |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>735,599,474.87</u></b> | <b><u>846,590,406.19</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                                 | <b><u>372,979.42</u></b>     | <b><u>1,188,610.00</u></b>   |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 372,979.42                   | 1,188,610.00                 |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                                                          | 372,979.42                   | 1,188,610.00                 |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг                                           | 71,369.42                    | -                            |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | 273,610.00                   | 1,160,610.00                 |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                                                    | 28,000.00                    | 28,000.00                    |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг                                              | 28,000.00                    | 28,000.00                    |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>735,226,495.45</u></b> | <b><u>845,401,796.19</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 735,226,495.45               | 845,401,796.19               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 623,175,477.00               | 623,175,477.00               |

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

|            |                                                        |                              |                              |
|------------|--------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                            | (181,696,524.53)             | (71,521,223.79)              |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                     | (181,696,524.53)             | (181,696,524.53)             |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                   | -                            | 110,175,300.74               |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                       | 293,747,542.98               | 293,747,542.98               |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН<br/>VI=IV+V</b> | <b><u>735,599,474.87</u></b> | <b><u>846,590,406.19</u></b> |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код  | Үзүүлэлт                                                            | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                              | <b>536,479,900.00</b> | <b>879,852,950.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                          | -                     | <b>84,870,450.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                  | -                     | 84,870,450.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                    | -                     | 84,870,450.00         |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                           | -                     | 7,047,600.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                   | -                     | 77,822,850.00         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>536,479,900.00</b> | <b>794,982,500.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 506,101,000.00        | 755,951,000.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 506,101,000.00        | 755,951,000.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 30,378,900.00         | 39,031,500.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 30,378,900.00         | 39,031,500.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                  | <b>517,884,925.86</b> | <b>769,677,649.27</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                | <b>517,884,925.86</b> | <b>769,677,649.27</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | 513,663,071.64        | 749,133,476.68        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                            | 354,252,072.36        | 542,585,696.79        |
| 210101      | Үндсэн цалин                                                        | 250,524,221.55        | 338,101,232.11        |
| 210102      | Нэмэгдэл                                                            | 85,589,273.71         | 172,060,204.68        |
| 210104      | Урамшуулал                                                          | 18,138,577.10         | 32,424,260.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>               | 43,814,110.97         | 67,058,142.90         |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                  | 30,373,157.12         | 46,304,386.08         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                  | 3,547,871.43          | 5,364,525.62          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                   | 3,098,212.51          | 2,682,263.03          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                | 757,268.56            | 3,191,170.57          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                               | 6,037,601.35          | 9,515,797.60          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                    | 26,908,445.78         | 32,302,027.41         |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                    | 5,295,445.78          | 7,297,339.91          |
| 210302      | Түлш, халаалт                                                       | 21,613,000.00         | 25,004,687.50         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                             | 2,530,000.00          | -                     |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                         | 2,530,000.00          | -                     |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                             | 43,622,320.00         | 43,881,960.00         |
| 210502      | Хоол, хүнс                                                          | 43,622,320.00         | 43,881,960.00         |

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

|             |                                                                             |                      |                       |
|-------------|-----------------------------------------------------------------------------|----------------------|-----------------------|
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    |                      |                       |
|             |                                                                             | 3,050,000.00         | 1,250,000.00          |
| 210604      | Урсгал засвар                                                               | 3,050,000.00         | 1,250,000.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             |                      |                       |
|             |                                                                             | 821,100.00           | 6,215,250.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | -                    | 5,655,250.00          |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                             | 821,100.00           | 560,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      |                      |                       |
|             |                                                                             | 38,665,022.53        | 55,840,399.58         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                             | 9,358,000.00         | 11,487,485.06         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                           | 2,463,000.00         | 5,581,900.00          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                          | 26,844,022.53        | 38,771,014.52         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                     |                      |                       |
|             |                                                                             | 4,221,854.22         | 20,544,172.59         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                               |                      |                       |
|             |                                                                             | 2,668,400.00         | 13,954,700.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | 2,668,400.00         | 13,954,700.00         |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> |                      |                       |
|             |                                                                             | 1,553,454.22         | 6,589,472.59          |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                       | 1,553,454.22         | 6,589,472.59          |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                                   | <b>18,594,974.14</b> | <b>110,175,300.73</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                                      |                      |                       |
|             |                                                                             | 29,993.60            | -                     |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                              | 29,993.60            | -                     |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                             |                      |                       |
|             |                                                                             | (29,993.60)          | -                     |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                              | <b>18,564,980.54</b> | <b>110,175,300.73</b> |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

| Дансны код  | Үзүүлэлт                                                            | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                       | <b>536,479,900.00</b> | <b>812,030,100.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                          | -                     | <b>17,047,600.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                  | -                     | 17,047,600.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                    | -                     | 17,047,600.00         |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                           | -                     | 17,047,600.00         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>536,479,900.00</b> | <b>794,982,500.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 506,101,000.00        | 755,951,000.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 506,101,000.00        | 755,951,000.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 30,378,900.00         | 39,031,500.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 30,378,900.00         | 39,031,500.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                        | <b>488,113,003.91</b> | <b>737,278,719.11</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                | <b>488,113,003.91</b> | <b>737,278,719.11</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | <b>483,891,149.69</b> | <b>716,734,546.52</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                            | 349,670,113.91        | 546,092,179.92        |
| 210101      | Үндсэн цалин                                                        | 246,513,567.04        | 336,289,169.13        |
| 210102      | Нэмэгдэл                                                            | 85,320,950.24         | 177,378,750.79        |
| 210104      | Урамшуулал                                                          | 17,835,596.63         | 32,424,260.00         |

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

|             |                                                                             |                       |                        |
|-------------|-----------------------------------------------------------------------------|-----------------------|------------------------|
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | 48,314,700.00         | 63,623,029.19          |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                          | 32,853,600.00         | 40,996,929.19          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                          | 3,865,600.00          | 5,656,600.00           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                           | 3,092,100.00          | 2,828,300.00           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                        | 773,200.00            | 2,828,300.00           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                       | 7,730,200.00          | 11,312,900.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                            | 25,375,445.78         | 31,192,027.41          |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                            | 5,295,445.78          | 7,297,339.91           |
| 210302      | Түлш, халаалт                                                               | 20,080,000.00         | 23,894,687.50          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                                     | 44,838,790.00         | 36,909,550.00          |
| 210502      | Хоол, хүнс                                                                  | 44,838,790.00         | 36,909,550.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | 3,050,000.00          | 1,250,000.00           |
| 210604      | Урсгал засвар                                                               | 3,050,000.00          | 1,250,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 821,100.00            | 7,747,375.00           |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | -                     | 5,837,250.00           |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                             | 821,100.00            | 1,910,125.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 11,821,000.00         | 29,920,385.00          |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                             | 9,357,800.00          | 24,338,485.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                           | 2,463,200.00          | 5,581,900.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                     | <b>4,221,854.22</b>   | <b>20,544,172.59</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                               | 2,668,400.00          | 13,954,700.00          |
